



Түр хорооны хуралдааны тэмдэглэл
2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 07-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	2
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	3-4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5-16
<i>1. “Нэг. “Хянан шалгагчийн ажлын даалгавар батлах тухай” Түр хорооны тогтоолын төсөл</i>	3-16
<i>2. “Хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх тухай” Түр хорооны тогтоолын төсөл</i>	16-17

Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы Хянан шалгах түр хороо /Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий/-ны 11 дүгээр сарын 07-ны өдөр /Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 10 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 19 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: С.Ганбаатар;

Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Сүхбаатар.

Нэг. “Хянан шалгагчийн ажлын даалгавар батлах тухай” Түр хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх Ж.Монголжингоо, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт М.Мандхай нар байлцав.

Түр хорооны дарга Б.Энхбаяр “Хянан шалгагчийн ажлын даалгавар батлах тухай” Түр хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Д.Ганбат нарын тавьсан асуултад Түр хорооны дарга Б.Энхбаяр хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Т.Доржханд, Б.Жаргалмаа, М.Оюунчимэг нар үг хэлэв.

Б.Энхбаяр: “Хянан шалгагчийн ажлын даалгавар батлах тухай” Түр хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5

Татгалзсан: 1

Бүгд: 6

83.3 хувийн саналаар Түр хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх тухай” Түр хорооны тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөх Ж.Монголжингоо, мөн газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт М.Мандхай нар байлцав.

Түр хорооны дарга Б.Энхбаяр “Хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх тухай” Түр хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энхбаяр: “Хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх тухай” Түр хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 0
Бүгд: 6
100 хувийн саналаар Түр хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Түр хорооны дарга Б.Энхбаяр Түр хорооны хянан шалгагч, шинжээч томилох асуудлуудыг хэлэлцэх учир хуралдааныг хаалттай горимд шилжүүлбэ гэсэн горимын санал гаргав.

Б.Энхбаяр: Горимын саналыг дэмжбэ гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 2
Бүгд: 6
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг 12 цаг 59 минутад хаалттай горимд шилжүүлэв.

Түр хорооны нээлттэй хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 41 минут үргэлжилж, 10 гишүүнээс 8 гишүүн хүрэлцэн ирж, 80 хувийн ирцтэйгээр 13 цаг 00 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ
ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “засаг”
танхим 12 цаг 19 минут.

ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Энхбаяр: Гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил, үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах, иргэд олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны 2023 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн хуралдаан гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул нээснийг мэдэгдье.

Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Хянан шалгах түр хорооны хянан шалгагчийн ажлын даалгавар батлах тухай тогтоолын төсөл,

2.Хянан шалгах түр хорооны хянан шалгалтыг ажлыг эрчимжүүлэх тухай тогтоолын төсөл, шалгалтын удирдамжийг хавсралтаар батална,

3.Хянан шалгах түр хорооны тогтоол, хянан шалгах түр хорооны

шинжээчдийг томилох тухай төсөл гэсэн ийм 3 асуудал байна.

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Эхний асуудал. Хянан шалгагчийн ажлын даалгавар батлах тухай тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Хянан шалгагчийн ажлын даалгавар батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг, 44.1, 44.3, 44.4, 44.5-ыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос тогтоох нь:

1.Төрийн болон орон нутгийн өмчит өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа, ажил үйлчилгээ, худалдан авалтын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх нотлох баримтыг шинжлэн судлах нээлттэй сонсгол зохион байгуулах иргэд олон нийтийг мэдээллээр хангах, хяналт шалгалтын тайланг Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны хянан шалгагчийн ажлын даалгаврыг хавсралтаар баталсугай.

2.Ажлын даалгаварт дурдсан тусгай шалгалтыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж, хянан шалгах түр хорооны сонсголд бэлтгэн танилцуулахыг хянан шалгагч нар тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хянан шалгах түр хороонд тус тус даалгасугай гэсэн тогтоолын төсөл байна.

Холбогдох ажлын даалгаврыг хавсралтаар батлахаар оруулсан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдолтойгоор асуулт асуух гишүүд байна уу? Байна. Ганбат гишүүнээр тасаллаа.

Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

Ганбат гишүүн эхлээд асуултаа асууя.

Дараа нь Цогтгэрэл гишүүн асууя.

Д.Ганбат: Яах вэ, бид бүхэн бүгдээрээ, ер нь иргэд олон нийт ч гэсэн аягүй хүлээлттэй байгаа л даа. Энэ нүүрсний сонсгол гэж товчоор нэрлээд байгаа энэ сонсголыг үр дүнтэй ажил хэрэгч болоосой гэсэн тийм хүлээлт байна. Гэтэл өнөөдөр, одоо, энэ Хянан шалгах түр хороо маань байгуулагдаад бараг 2, 3 сар болчихлоо. Гэтэл бид нар өнөөдөр л гэхэд энэ хянан шалгагчийн ажлын даалгаврыг ингээд өгөх нь.

Энэ хянан шалгагч нар маань хангалттай хугацаа байгаа юу? Ямар хугацаанд? Энэ дээр даалгавруудыг хараад байхад нэлээн том том 8, 9, 10-аад даалгавар байна. Энэ бүх юмнуудыг бэлдээд ингээд оруулж ирж чадах боломжтой юу? Энэ яагаад би асууж байна вэ гэхээр энэ олон түмний өмнө нээлттэй болно. Нээлттэй болдог

учраас бүх юм нотолгоотой хэн нэгнийг үлдээсэн зүйл байхгүй. Хэн нэгнийг бас хэлмэгдүүлсэн ийм юм байх ёсгүй. Ийм байдлаар танилцуулагдаж бид нар хоорондоо ярилцах энэ мэдээлэл дээр бас иргэд ч гэсэн ингээд мэдэх ёстой.

Тэгээд хөнгөн хуумгай хандаад нэр төдий юм хийгээд ингэчихвэл бас энэ Түр хорооны нэр хүнд ч бай, энэ сонсголын нэр хүнд ч бай, иргэдийн мэдэх эрх ч бай энэ шинжээчдэд хангалттай цаг хугацаа өгөөгүй, зохих мэдээллийг авах ийм боломж энэ тэр нь байсан ч юм уу, байгаагүй ч юм уу гэсэн ийм маягтай асуудалд хандаад ийм үр дүн гарвал бид бүхэн яах вэ? Энэ талаар манай олонх одоо энэ Түр хорооны ихэнхийг бүрдүүлж байгаа. Тэгээд та бүхэн маань ямар бодолтой байдаг юм бэ? Би Хууль зүйн сайдаас энэ Түр хорооны даргаас бас асууж тодруулмаар байна.

Б.Энхбаяр: Түр хороо 7 сард Улсын Их Хурлын тогтоолоор байгуулагдсан 1 сарын өмнө түр хорооны даргаа тавьсан. Ингэж л ажилдаа орсон хүмүүс шүү дээ. Хянан шалгагч 5 хүнийг 1 сарын өмнө томилсон. Тэрний 3 нь намайг томилогдсоны дараа гараад явчихсан. Одоо би тэрнээс хойш 2 дээр нэмэх нь 10 хянан шалгагч бид хамтдаа томилчихоод байна. 12.

Өнөөдөр дахиад 3-ыг томилно. 3 дахь асуудлаар оруулж ирэх гэж байна. цар хүрээ бол мэдээж өргөн байгаа. Яагаад гэхээр Эрдэнэс Тавантолгой болон Жижиг Тавантолгой компаниудыг анх үүсгэн байгуулагдсанаас хойших 10 гаруй жилийн бүх баримтад үзлэг хяналт шалгалт хийгдэнэ. Энэнээс мөн өргөн хүрээтэй асуудлууд мэдээж шалгагдана. Тухайлбал одоо бидний энэ батлах гэж байгаа Хянан шалгагчийн ажлын даалгаварт худалдан авалттай

холбоотой 197 боть нотлох баримтад дүн шинжилгээ хийх даалгавар өгөх гэж байгаа юм. Энэ 197 боть нотлох баримт нь нийтдээ анх байгуулагдсанаас хойш Эрдэнэс Тавантолгой дээр гэхэд 2 мянган худалдан авалт байна. 2 мянган худалдан авах ажиллагаа болсон байна.

Надад хянан шалгагчдын танилцуулж байгаагаар энэ хэмжээний цар хүрээтэй ажлыг бол 6 мэргэжлийн хянан шалгагч ер нь бүтэн жилийн хугацаанд шалгадаг ажил гэж хэлж байгаа. Тийм одоо бол бид 2 худалдан авахын хянан шалгагчтай байгаа. Одоо дахиад 3-ыг нэмнэ. Ингээд мэдээж хугацаа богино байгаа гэдгийг бид хаа хаанаа мэдэж байгаа. Мөн нотлох баримтыг гаргуулах ажиллагаа өнгөрсөн 7 хоногоос эхэлсэн. Өнгөрсөн 7 хоногт хянан шалгагчдынхаа талыг нь Өмнөговь аймагт томилолтоор ажиллуулаад өнөө маргаашигүй ирж байгаа. Өөрөөр хэлбэл газар дээр нь бас гол нотлох баримтууд нь байгаа учраас тэндээс бас холбогдох нотлох баримтуудыг авчирч байгаа гэсэн үг. Мөн нотлох баримт гаргуулах ажиллагаан дээр бас эс үйлдэл гарч байна. Заримыг нь гаргаж өгөхгүй байгаа асуудлууд бас байна.

Тийм учраас ажлын даалгавар гаргаж байгаагийн утга нь бас ийм байгаа, ажлын даалгавар гарч байгаа юм. Нүүрсний борлуулалттай холбоотой тээвэрлэлттэй холбоотой нэлээн мэдээллүүд гаргуулж бас авах шаардлага үүсэж байна. Яагаад гэхээр өмнөх түр хороонд 2 зөрүүтэй мэдээлэл ирүүлсэн байна. Гаалийн байгууллагаас. Мэдээлэл нь зөрөөд байна.

Тийм учраас энэ нотлох баримтыг бэхжүүлэх шалгах ажиллагаа бол яг эх нотлох баримт дээр шинжээч үнэн зөв бодитой дүгнэлт гаргах шаардлагатай

байгаа учраас газар дээрх шалгалт хийх шаардлага үүсээд байна.

Мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгах шаардлагатай байна. Бас тээвэр борлуулалттай хамааралтай энэ компаниудыг бүгдийг нь үзэх шаардлага байна. Энийг УБЕГ-аас гаргуулах ажил хийх шаардлага байна. Өнгөрсөн хугацаанд бол нийтдээ 487 компани нүүрс тээвэр хийсэн байна. Энэ компаниудын харилцаа хамааралтай холбоотой мэдээллийг нэг бүрчлэн тулгаж шалгах шаардлага үүсэж байна. Өөрөөр хэлбэл шалгалтын үйл ажиллагаа бол нэлээн өргөн хүрээтэй явагдана. нүүрсчид их сандруу байгаа. Бас их мөнгөтэй байна. Сүүлийн үед асар их мөнгийг цутгаж байна. Хэвлэл мэдээлэл рүү. Гөлөг төөрүүлэх санаархал гаргаж байна.

Нүүрс тээвэрт сэтгүүлчид хүртэл машин тэрэг өгч хуваарилж, ноогдуулж амыг нь үдсэн асуудал ч гарч болзошгүй юм байна. Тийм учраас энэ асуудлыг их өргөн цар хүрээтэй нотлох баримтын эх сурвалжтайгаар ярихгүй бол болохгүй юм байна.

Тийм учраас бид хянан шалгахынхаа ажлыг эрчимжүүлж, өргөтгөж, мөн хянан шалгагчдынхаа цар хүрээг өргөтгөж байж энэ ажлын ард гарах нь. Цаг хугацаагаар шалтаглаж мэдээж зогсохгүй. Ер нь бол зогсохгүй хэзээ иж бүрэн, цогц байдлаар шалгаж дуусах хүртлээ л шалгана.

Тэрнээс биш цаг хугацаа дуусах гэж байгаа учраас та нар болих ёстой гэдэг байдлаар ийм юуг хүлээн зөвшөөрөхгүй л гэж ингэж үзэж байна. Мэдээж цаг хугацаа бол хэцүү байгааг Ганбат дарга өөрөө бас бас сайн ойлгож байгаа байх гэж бодож байна.

Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

Ганбат гишүүн тодруулъя.

Б.Энхбаяр: Манай түр хорооны дарга Энхбаяр сайд бас байгаа байдлыг ингээд мэдээлэл өгч байгаа нь маш сайн байна. Бид бүхэн 7 сард байгуулагдаад яг өнөөдрийн байдлаар 11 сар эхэлчихлээ. Үндсэндээ энэ түр хорооны ажиллах хугацааны бараг 70 хувь нь өнгөрчихсөн байна. Шинжээчдийн бүрэлдэхүүн ч гэсэн өнөөдөр 3, 4 хүн дутуу байна зарим хүмүүс гарч орж байна. Тэгээд өнөөдөр ч гэсэн АН-ын бүлгийг төлөөлөөд байгаа Цогтгэрэл гишүүн бид 2 л ямар ч байсан бүлгээ нэлээн хурал хуйдаа идэвхтэй оролцоод суугаад байгаа. Бусад хүмүүсийн төлөөлөлд би яриад яах вэ? Тэгэхээр энэ бүх ажил маань үр дүнтэй ингээд сайн яваасай л гэж бодож байна.

Тухайлбал урд хөрштэйгөө урд хөрш рүү л гарсан нүүрснүүд байгаа шүү дээ. Тэгээд манайхаас гарч.

Б.Энхбаяр: Ер нь хил гаалиар гарсан энэ нүүрстэй холбоотой мэдээлэл энийг шалгана даа. Тэгээд нотолгоожуулахад төвөгтэй асуудлууд мэдээж байгаа. Тэгээд шинжээч нар маань тултлаа л үзнэ. Цар хүрээгээ. Одоо нөгөө урьдчилаад шинжээч нар энэ даалгавраа гаргаад яг энэ ажлуудыг бүүр тухайлж газар дээр нь үз гэж явуулах гэж байна гэсэн үг байхгүй юу. Даалгавар баталж байгаад. Тэгээд л үзүүлнэ дээ. Боломжит богино хугацаанд л үзүүлнэ. Бид нар уу?

Д.Ганбат: Ер нь үр дүнтэй ажиллаж чадаж байна уу? Ямар байна.

Б.Энхбаяр: Бид нар уу? Үгүй та бид 2 үр дүнтэй л ажиллаж байгаа

байлгүй дээ. Та бид 2 манай Ганбат гишүүн маш их үр дүнтэй ажиллаж байгаа шүү дээ. Байнга ирж байгаа. Түр хорооны хуралд сууж байгаа, тийм. Би энэ хуралдаа суудаггүй гишүүдийг яриад байгаа байхгүй юу. Та бид 2 бол их л үр дүнтэй ажиллаад байх шиг байна. Та надаас үр дүн нэхээд байгаа байхгүй юу. Та бид 2 бие биеэсээ үр дүн нэхээд яах вэ. Ганбат ах.

Одоо бусдаас үр дүн нэхнэ. Хоёулаа нийлж байгаад хамтдаа өөр хүмүүсээс үр дүн нэхнэ.

Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Нүүрсний сонсголын ажлын хэсэг түр хороо бас удаа дараа хуралдаж байгаа. АН-ын бүлгийн гишүүд бүлэг төлөөлж орсон гишүүд бүхий л хуралд оролцоод байр суурь илэрхийлээд тэр тусмаа энэ хурал, энэ сонсгол цаг хугацаандаа болох ёстой чанартай болох ёстой гэдэг байр суурьтай энэ нөхцөл бололцоог хангаж өгье. Тэр шинжээч томилгё, шинжээчийг сольё бүхий л асуудлыг 100 хувь л дэмжиж л өнгөрсөн хугацаанд явж ирж байгаа.

Цаашидаа ч бас ингэж байж цаг хугацаандаа дахиад сонсгол чанартай болох ёстой гэдэг байр суурийг байнга илэрхийлж байгаа. Тэр тусмаа бас ковидын сонсгол гэдэг 20 их наядын байж болох мөнгөн дүн бүхий ковидын сонсгол гэдэг асуудал хуулийн бас нэг ийм гацаанд орчхоод байгаа юм. Энд болохоор одоо Нүүрсний түр хороон дээр бараг 10 гаруй шинжээч тавиад дахиад шинжээч тавигдаад ингээд ажиллах юм байна, энэ зөв зүйтэй, энийг дэмжиж байгаа. Дэмжиж байгаа. Энэ ковидын сонсгол дээр бид нар 3 шинжээчийг 14 хоногийн хугацаатай тавиад өгөх хөрөнгө санхүүг шийдэж өгөөч гээд

өнөөдөр юм байхгүй л энэ ажил цаашаа явах боломжгүй болчихоод байгаа юм.

Ковид дээр гуравхан шинжээчийг 14 хоногийн хугацаатай тавиад өгөөч гэдэг л бид нар нөхцөл бололцоог шаардаж байгаа. Энд 12 шинжээч тавигдсан байна уу? Дахиад шинжээч тавигдах юм байна. Би бас харьцуулж маргаж байгаа юм биш. Тэгэхдээ энэ зөв ингэж тавих ёстой энийг ингэж байж чанартай явах ёстой. Нөгөө талдаа сөрөг хүчний ахалж байгаа тэр сонсголын ажиллах орчин нөхцөл бололцоог бас эрх баригчид биелүүлж өгөх ёстой.

Тэгэхээр энэ энэ орчин нөхцөл үнэндээ бас өнгөрсөн хугацаанд биелэхгүй явж байгааг би бас хэлэх ёстой гэж бас бодож байна. Тэгээд төгсгөлд нь энэ Түр хорооны даргаас нэг л зүйл байгаад байна л дээ. Одоо тэр хэрэг нь шалгагдаж байгаа хүмүүсээс, тэр тусмаа тэр Эрдэнэс Тавантолгой компанийн захирлаар ажиллаж байсан Ганхуяг гэдэг хүн энэ сонсголд оролцох уу? Тэр хүн өнөөдөр шүүхээр шийдвэрлэгдэж буруутан болоогүйгээс хойш тэр хүн бас тодорхой хэмжээнд мэдээллээ хэлээд хуулиар зөвшөөрөгдсөн хязгаарлагдсанаас бусад мэдээллээ хэлээд явах боломжтой байх болов уу? Тэгэхээр энэ хурал дээр энэ нүүрсний сонсгол 12 сарын 4-нд болох гэж байгаа энэ сонсгол дээр тэр захирлаар нь ажиллаж байсан хүнийг ирүүлэх боломж бололцоог та юу гэж бодож байна? Ингэж байж ард түмэнд бодит мэдээллүүд гарна л гэж. Би бол ийм л бодолтой байна. Ингэхгүй бол тэгээд цар хүрээгээ хумиад тодорхой нэг ийм бэлтгэсэн мэдээллийн хүрээнд энэ сонсгол бэлтгэсэн мэдээлэл, дуудсан гэрчүүдийн хүрээнд л энэ мэдээлэл болоод өнгөрөх магадлал өндөр байх вий гэдэг

болгоомжлол үндсэндээ байгаагаа бас нуух юм алга.

Тэгэхээр тэр Ганхуяг болоод бусад яг Ганхуягтай ижил түвшний мэдээлэл бүхий асуудалд холбогдож байгаа тэгэхдээ бас тэр шүүхээр шийдвэрлэгдэж буруутан болоогүй тэр хүмүүсийг энд оролцуулах боломж бололцоог яаж хангах гэж байгаа вэ?

Б.Энхбаяр: Ганхуяг захирал нүүрсний сонсголд гэрчээр оролцох эсэхийг бид одоо шийдэх гээгүй. Бид одоо хяналт шалгалтын ажлын даалгавраа эрчимжүүлэх тухай тогтоол ярьж байгаа. Нүүрсний тов зарлахтай хамт хэнийг ямар асуудлаар гэрчээр дуудах вэ гэдэг асуудал сонсгол болохоос 7 хоногийн өмнөх Түр хорооны хурлаар шийдэгдэнэ. Өөр хуульд нь тийм байгаа. Тэгэхээр тэр хурал дээр энэ асуудал яригдах нь гэж хариулт өгье. Гишүүд асуулт асууж дууслаа.

Уг байгаа билүү? Тогтоолын төсөлтэй холбоотойгоор уг хэлэх гишүүд байна уу? Ганбат гишүүн. Жаргалмаа гишүүнээр тасаллаа. Ганбат гишүүн үгээ хэлье.

Д.Ганбат: Манай АН-ын бүлгээс Цогтгэрэл дарга маш чухал асуудлыг хөндлөө. Ер нь олонх маань энэ нүүрсний түр хороог даргалж байгаа. Тэгээд дотор нь олонх байгаа энэ өнгөрсөн 8 жилийн хугацаанд бүгдээрээ та нарын найз нөхдүүд хамт нам нэгтнүүд ийм хүмүүс энэ нүүрсний бизнесийг төрийн өмнөөс толгойлоод хийж байсан, ийм байсан. Тэгээд энэ хүмүүсийн та бүхэн бас найз нөхдийгөө бас хамтран ажилласан хүмүүсээ дуудаж бариад ялахад хэцүү л байгаа байх. Олон ч баатрууд, олон ч гавьяатууд, энэ нүүрснээс төрсөн олон ч хүмүүс

баяжсан. Хамгийн хохирсон хүмүүс бол Монголын ард түмэн л байгаа.

Өнөөдөр багш нарын цалин нэмж чадахгүй байгаа, нэмэхгүй байгаа, эмч нарын цалинг нэмэхгүй байгаа, тэтгэврийнхний тэтгэврийг нэмэхгүй байгаа. Энэ бүх асуудал энэ нүүрстэй холбоотой. Тэгээд нүүрс маань өөрсдөө бас гарахдаа нөгөө төмөр зам нь ч мухар төмөр зам болоод гацаад энэ улс орны хамаг хөгжилтэй холбоотой л ийм л зүйл байгаа л даа.

Тийм учраас одоо тухайн үед тэнд нь ажиллаж байсан энэ хүмүүсийг дуудаж асууж ингэж ярилцаж иргэдийнхээ мэдэх эрхийг хангахгүйгээр энэ сонсгол өрөөсгөл болно оо. Хамгийн чухал асуудал байна.

Нөгөө нүүрсний хэрэгт орооцолдсон энэ хүмүүс маань эрүүл мэндийн хувьд янз бүрийн нөхцөл байдалд хамгаалалтад авах ямар нэгэн байдлаар ар гэр бусад зүйлс нь аюулд өртөхөөргүй тэр баталгааг нь өгчих. Ингэж сонсохгүй бол иж бүрэн болохгүй. Энэ талаар бас манай АН-ын бүлэг бол цөөнх бас маш их санаа зовж байна. Тэр бүх юмыг бий болгохгүй бол энэ чинь тэд нарыг дугуй болгох янз бүрийн тийм маш их мөнгө байгаа шүү дээ одоо. Сая манай Түр хорооны дарга хэллээ.

Түрүүчээсээ одоо хэвлэл мэдээллээр ингээд хөдлөөд эхэлчихсэн байна, маш их олон троллууд ажиллаж байна, маш их мөнгө энэний гадна явж байна гэх мэтчилний зүйл байдаг. Тэгээд энэ сонсголыг бас иж бүрэн болгохын тулд мэдээж хэрэг урд хөрштэйгөө бид нар бол зохих байгууллагатай нь харьцах ёстой. Энэ нүүрсний зөрөө гэхэд ямар их зөрөө байна, хэчнээн хэмжээний нүүрс гарсан юм. Энэний мөнгө нь яаж орж

ирсэн юм гэсэн энэ асуудлууд байна. Энэ бүх юманд бид нар нэлээн тийм нягт нямбай хандаж ингэхгүй л бол одоо хэн нэгэн хүнийг хэлмэгдүүлж болохгүй.

Хэн нэгэн хүнийг бас энэ асуудлаас хоцроож болохгүй. Энэний төлөө л мэдээж хэрэг бид нар энд сууж байгаа. Ялангуяа цөөнхийн сөрөг хүчний бид нар бол. Мэдээж хэрэг бид нарт бол тэр эрх мэдэл энэ хүмүүсийг дуудаад асуух ийм боломж алга. Монголын ард түмний өмнө үүрэг хариуцлага хүлээсний хувьд энэ олонх энэ ажлаа хийх байх. Хийх хугацаа нь бол хамгийн сүүлийн хугацаа энэ байна. Мэдээж хэрэг танай танай ч юу байх вэ дээ өнөөдөр энэ Засгийн газрыг тэргүүлж байгаа МАН-ыг толгойлж байгаа нөхдүүд амаараа ярьж байгаа шүү дээ. Авлигатай, энэ бүх зүйлтэй, нүүрсний хулгайтай бид нар тэмцэнэ л гэж байгаа. Ярих нэг өөр хэрэг. Энийг бол амьдрал дээр ажил хэрэг болгох өөр. Ажил хэрэг болгох гэж байгаагийн илэрхийлэл нь эндээс гарна.

Тэрнээс биш энэ асуудалтай холбогдоод шийтгэл хүлээчихсэн хүмүүс алга байна. Улам л их хулгай хийж байна. Улам л их луйвар хийж байна. Монголын ард түмэн Монголчууд бүгд ард нь ингээд хохироод улам үлдэж байна. Энэ дээр бид нар хариуцлагатай хандъя гэсэн ийм санал бодол байна. Богинохон хугацаанд нэр төдий юм хийгээд энэ асуудлыг өнгөрөөх биш, энийг ямар байсан юм, юу болсон юм, цаашидаа ямар байх юм гэдэг асуудлыг нь бид нар гаргаж ирж чадвал цааш цаашидаа энэ бүх хүмүүст дохио болох байх. Монголын ард түмэн ч гэсэн цаашидаа хяналтаа тавих, ядаж хүмүүст нь хариуцлага тооцохгүй бол энэ намд нь хариуцлага тооцох ийм сонгогчид байгаа шүү гэдгийг сануулах мэдэх эрхийг нь хангаж өгөх ийм зүйл байгаа гэдгийг бас хэлчихье. Баярлалаа.

Б.Энхбаяр: Доржханд гишүүн үгээ хэлье.

Т.Доржханд: Баярлалаа. Парламентын хяналт шалгалтын яг энэ механизм үр дүнтэй юм бэ гэдгийг бид нар Хөгжлийн банкны түр хорооны хяналт шалгалт нотлох баримтын хүрээнд иргэдэд маш сайн ойлгуулсан гэж бодож байна. Тэгээд энэ Түр хороо онцлогтой. Өмнөх нь бол байгуулагдаад тэгээд тодорхой шалтгааны улмаас сунасан. Одоо ингээд дахиад 18 дахь сар дээрээ ингээд бид нар энэ ажлыг хийх гэж байна. Тийм тэгээд энийгээ харин үнэхээр маш сайн хийх нь бол зүйтэй. Энэ дээр нэг л асуудал байгаа. Хөгжлийн банкны хулгай гээд бид нар нотлох баримтын хүрээнд маш их ажил хийгээд гаргаж ирээд байхад яг хариуцлага тооцсон тооцуулсан этгээд нь ингээд харахлаар хэдэн Хөгжлийн банкны дунд шатын захирлууд л байгаа. Тав, зургаахан хүн нэг дунджаар 3-аас 4 жилийн нэг ял авсан. Тэрийгээ давж заалдах шатанд яваад байгаа юм. Нэг ч улс төрч байхгүй, сайд дарга нар байхгүй.

Нөгөө нэг өмнө нь Ерөнхийлөгч, Ерөнхий сайд байсан нөхдүүд огт байхгүй. Юу ч байхгүй. Тэгээд үр дүнд нь ингээд хэдийгээр бид нар парламентын хяналтыг энд ингээд хийгээд иргэдийнхээ өмнө нээлттэй мэдээллүүдийг нь гаргаад тавьсан ч гэлээ гэсэн тэр хуулийн байгууллага дээр очоод замхраад байна. Мэдээж бид хууль, шүүхийн шийдвэрт нөлөөлөх боломж байхгүй. Гэхдээ бид нар хангалттай нотлох баримтуудыг нь гаргаж өгсөн шүү дээ. Хуулийн байгууллагуудын төлөөллүүдийг дуудаж авчирсан. Яг энэ жишгээр ингээд нүүрсний сонсгол маань хийгддэг. Дахиад нөгөө хариуцлага хүлээдэг ийм этгээдүүд

байхгүй тохиолдолд яах билээ гэдэг асуудал байгаа юм. Тэгээд үүнтэй холбоотойгоор би одоо энэ ажлын хэсгийн ахлагч, Хууль зүйн сайдад энэ хуулийн хариуцлага хүлээдэг механизмыг мэдээж хараат бус бие даасан, гэхдээ ийм нөгөө нөлөө оролцуулахгүй байдлаар бүгдээрээ бас энийгээ ярьж байгаад системийг нь сайн хийж өгөхгүй бол одоо ингээд үр дүн нь бол эцсийн эцэст хариуцлага хүлээснээр гардаг. Гэтэл Монголын түүхэнд хамгийн том дүнтэй ийм авлигын асуудал яригдаж байхад тэнд ингээд хууль шүүхийн байгууллага дээрээ очоод нөгөө нэг хэдэн нэг компанийн хэдэн дунд шатын захирлууд нь ял аваад явчих юм бол энэ бол тэгээд парламентын хяналт шалгалт хийх шаардлага ч байхгүй, иргэд ч гэсэн итгэлээ алдана шүү гэдэг нэг ийм болгоомжлол байгаа юм.

Тэгэхлээр энэ ажлын хэсгийнхээ гишүүдэд, Түр хорооныхоо гишүүдэд, мөн ажлын хэсгийн Түр хорооны ахлагчидуудад хандаж хэлэхэд бид нар энэ дээр онцгой анхаарах ёстой юм билээ. Дараагийн нэг зүйл нь энэ дүнгээрээ маш том шүү дээ. Хөгжлийн банк чинь 1,8 их наяд төгрөг байсан бол энэ чинь бол яг ингээд орлого цаана нь байсан мөнгө гээд тэгэх юм хэд дахин илүү их дүнтэй. Гүйлгээнүүд нь маш их, худалдан авалтууд нь маш олон, хамралт нь одоо их олон хүнийг хамарсан болоод нүсэр ажилтай.

Тэгээд энэ дээр бол мэргэжилтнүүдийг аваад худалдан авах ажиллагааны шинжээчдийг аваад нэмээд л яваад байх нь зүйтэй. Гэхдээ энийгээ нөгөө уялдуулаад ингээд явахгүй бол 4, 5 шинжээч нарынхаа мэдээллийг уялдуулаад бас ингээд явахгүй бол тус тусдаа өөрсдийнхөө хариуцсан ажлыг аваад л тайлагнаад явчих юм бол үр дүн

бас гарахааргүй юм байна гэж хараад байгаа юм. Тухайлбал оффтейк гэрээ 18 их наяд нууцалсан юм байгаа шүү дээ. Яг энэ чиглэлээр явж байгаа шинжээчид нь мэдээллээ гаргаад нөгөө талд нь худалдан авалтыг яг биет байдлаар алдагдсан хэмжээ гээд байна. Хуулийн байгууллагуудын экспертүүд байна. Тэгээд энэ бүгд чинь өөр өөрсдийнхөө хариуцсан юмаа ингээд яриад л явчих юм бол үр дүн гарахгүй юм байна лээ л дээ. Тэгэхлээр энийгээ нөгөө уялдуулах ажил нь манай ажлын хэсэг дээр л хийгдэх юм шиг байна лээ. Энийгээ базаж байгаад бүгдээрээ энэ хэсэг дээр бол ийм хэмжээний хулгай гарсан байна.

Тэгээд ийм хүмүүс оролцсон байна. Энэ хэсэг дээр бол ийм байна гэдгийг яг албан тушаалтай нь зарлаж байгаад, яг тэр хүмүүсийг авчирч байгаад явахгүй бол тэгээд л үр дүн хүрэхгүй юм байна лээ л дээ. Би бол энэ Цогтгэрэл гишүүнтэй санал нэг байна. Ганхуяг гэдэг хүнийг авчрах хэрэгтэй. Тухайн үеийн шийдвэр гарсан бүх дарга нарыг бүгдийг нь авчирч байгаад, гадагшаа зугтаасан нөхдүүдийг бүгдийг нь ингэж байлцуулж байгаад тэгээд яримаар байгаа байхгүй юу.

Тэр нь эрх барьж байна уу барихгүй байна уу үл хамаараад бүх дарга нарыг авчирч байгаад ярих хэрэгтэй. Ингэж байж дахиж хулгай хийж болдоггүй юм байна гэдэг ойлголтыг өгөх юм бол цаашид энэ том хулгайн хэргүүд дарагдана даа. Тэгээд том хулгай хаана байна? Нүүрс дээр байгаа, зэс дээр байгаа, банк санхүүгийн байгууллагууд дээр л байх ёстой. Энийгээ л бүгдээрээ аягүй сайн хийгээд хариуцлага хүлээлгэх байдал дээр л анхаарах хэрэгтэй байна.

Б.Энхбаяр: Жаргалмаа гишүүн үг хэлье.

Б.Жаргалмаа: Энэ түр хорооны хурал маань олон нийтэд бас нээлттэй явж байгаа юм шиг байна. Яагаад гэвэл гишүүдийн хэлж байгаа үгнээс бас олон нийт хэвлэл мэдээллийнхэн маань харж байгаа бололтой. Уг нь түр хорооны хурал 11 цагаас зарлагдсан. Түр хорооны дарга Оюунчимэг гишүүн бид 3 ирц бүрдэхийг хүлээж 11 цаг 30 минут хүртэл сууж байгаад, 12 цаг хүртэл түр хойшлуулъя гээд хойшлуулаад одоо хурал маань явагдаж байна. Би юу хэлэх гээд байна вэ гэвэл Улсын Их Хурлын гишүүд хүлээсэн үүргийнхээ дагуу харьяалагдсан түр хороо болон Их Хурал, Байнгын хороо, ажлын хэсгийнхээ хуралдаа цагтаа орж бие биеэ хүндэлдэг баймаар байна. Тэгээд би яагаад хурлынхаа өмнөх би хуралд суусан нэг удаагийн хуралд би Ерөнхийлөгчийн ажилчид, Их Хурлын дэд даргатай Швед улсад томилолтоор ажиллаж байсан учраас би таслаагүй. Хэлэх үгээ хэлнэ ээ, Цогтгэрэл дарга аа. 11 цагт цагтаа ирье. Би нэг ч удаагийн хурал таслаагүй Улсын Их Хуралд нэг ч удаа хоцроогүй гэдгээрээ Их Хурлаас бас тодорхой хэмжээний юм авч байсан. Өөрөөр хэлэх юм бол 100 хувийн ирцтэй гишүүнээр би бас тодорч байсан шүү. Тодорч байсан гээд хэлчихье. Тантай адилхан үг хэрэглэчихье.

Өөрөөр хэлэх юм бол камерын өмнө бас тодрох хүмүүс манай Түр хорооны хуралд байдаг юм байна хүлээсэн үүргээ биелүүлээд цагтаа хуралдаа ирж байя. Бид бие биеийгээ хүндэлж байя гэдэг үгийг хэлэх гэсэн юм. Хэн ч гэсэн хаана ч гэсэн ажилтай байгаа. Зүгээр сая яг Түр хорооны дарга маань бас хэлсэн. Тогтоолын төсөлтэй холбогдуулан санал хүсэлт байна уу гэж.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан хянан шалгагчийг бас ажиллах боломжоор нь хангахгүй байна гэдэг энэ нөхцөл байдал бас уурхайд төрийн өмчит компаниуд дээр минь бас үүссэн бололтой. Түр хорооны энэ хянан шалгагчаар томилогдож байгаа хүмүүс маань бас тодорхой хэмжээнд хамаарал бүхий этгээдүүд байж болзошгүй гэдэг ийм мэдээллүүд байгаа. Энэ дээр бас Түр хорооны дарга бас өөрөө тайлбар хэлнэ биз. Бид хэнийг сонгох вэ гэдэг дээр бас анхаарах ёстой байх. Ер нь нүүрстэй холбоотой асуудал олон нийтийн анхаарлын төвд байгаа нь үнэн. Энэ холбоотой бид гол экспортын бүтээгдэхүүн болдог нүүрс дээрээ хяналт тавьж эргээд эдийн засагт орж байгаа тэр дүн мэдээллийг өргөжүүлэх нэмэгдүүлэх. Хэрвээ үнэхээр хулгайн луйвар цавчаа байдаг түүнийг олон нийтэд танилцуулах, мэдээлэх. Сая Доржханд гишүүний хэлсэнчлэн хариуцлага тооцох асуудал яг энэ Түр хорооны ажлын үр дүнд ерөөсөө харагддаггүй. Өөрөө Түр хороо өөрөө хариуцлага тооцох эрх үүсгэхэд хүлээдэггүй учраас энэ нэг асуудал байдаг. Зүгээр магадгүй Хууль зүйн сайд энэ Түр хороог ахалж байгаа учраас бид бусад хууль дээр бас энэ дээр тодорхой хэмжээний өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага байгаа болов уу гэдэг ийм бодолтой байдаг.

Хариуцлага яаж тооцох вэ гэхлээр Түр хороо тийм эрхгүй гэдэг үүрэг хүлээсэн биш гэдэг ийм зүйл яригдаад байдаг л даа. Тэгэхлээр энэ дээр бид нар ер нь хариуцлагын асуудлыг яаж чангатгах ёстой юм бэ?

Нөгөө талаар нүүрс маань зөвхөн хил гаалиар ачиж гаргахаас гадна Хөрөнгийн биржээр худалдаалагдаж байгаа асуудал байгаа. Энэ дээр хяналт

тавих тэр боломж нь өөрөө хянан шалгагч нарт олгогдсон байгаа болов уу гэдэг асуудал байна. Зөвхөн худалдан авах ажиллагаанд хяналт тавихаас гадна яг борлуулалт дээр бид нар хяналт тавих зайлшгүй шаардлага байгаа учраас энэ асуултыг асууж байгаа юм.

Тэгээд яг одоогийн байдлаар бид ажлын даалгавар баталж байна. Өмнөх хуралдаанаар бид нар уучлаарай би өмнөх хуралд үнэхээр байгаагүй томилолттой байсан учраас. Бид бас ажлын цагалбараа баталсан. Түр хорооны ажлын цагалбараа баталсан. Тэр ажлын цагалбар дээр бас бид нар өөрсдөө очиж ажиллах ийм хуваарь байсан. Тэр хуваарь яг нөгөө календарчилж гараагүй учраас бас мэдээлэл байхгүй байна.

Тэгэхлээр энэ талаар бас нэг мэдээлэл өгөөч гэдэг хүсэлт байна.

Б.Энхбаяр: Энэ үг хэлж байгаа шүү дээ.

Оюунчимэг гишүүн үг хэлье. Асуулт дуусчихсан шүү, түрүүн тасалчихсан. Одоо үг хэлж байгаа.

М.Оюунчимэг: Цогтгэрэл дарга аа би нэг үг хэлчихье. Бид нар маш хариуцлагатай энэ нүүрсний асуудал болох Түр хорооны гишүүд 12 сарын 4-нд эхний сонголт хийнэ гэж байгаа. Одоо энд чинь бараг маш бага хугацаа үлдсэн байна. Тэгэхээр шинжээчид бас заримыг нь өөрчилж, заримыг нь томилж явж байна. Тэгэхээр бид нар энд Түр хорооны гишүүд маань үнэхээр хариуцлагатай хандаж ажилдаа ирцдээ ороод ажлаа хувааж аваад хариуцлагатай баймаар байна. Яг үнэнийг хэлэхэд. Бүх хуралд ирээд л хүлээгээд суугаад л байна. Бид нар ч гэсэн маш олон ажилтай, төсвийн ажлын хэсгээс өгсүүлээд л. Би

жишээлбэл нээрээ тэгж байна шүү дээ одоо Энхбаяр гишүүн бид 2 байгаа. Цогтгэрэл гишүүн өмнө нь эртээд ирчихсэн байсан. Би бас тийм учраас харин одоо ирцээ бүрдүүлье, цагтаа ирцгээе бүгдээрээ. Цагтаа ирж байгаад асуудалдаа орохгүй бол одоо энэ нөгөө микрофоны өмнө нээрээ бүгдээрээ яагаад л микрофоны өмнө бүгдээрээ болоод байгаа юм шиг байна.

Ганбат гишүүн би нөгөө урдаас харж байгаа юм болохоор та инээгээд байх шиг байгаа юм. Ер нь би Доржханд гишүүн нэг жоохон идэвхтэй байя гэж хэлэх гээд байгаа юм. Нэрийг нь шууд хэлчихье тийм. Яагаад гэвэл нээрээ микрофонтой ингээд яриад байдаг, тэгэхгүй бол энэ чинь асуудал нээрээ тоглоом биш болоод байна шүү дээ. Хүмүүс гадаа хүлээлт их байгаад байна. Энэ түр хорооны гишүүд нь цөөхөн. Тэгээд ирц нь ч бүрдэж байгаа юм шиг 12 сарын 4-нд эхний сонсголоо хийж чадах юм уу үгүй юм уу? Яагаад гэвэл бид нар бас юмтайгаа танилцмаар байна шүү дээ.

Өнөөдөр энэ шинжээчид дотор манай Цогтгэрэл гишүүн, Ганбат гишүүнээ бүгдээрээ бас нэг анхаарал хандуулахгүй бол шинжээчээр орж ирж байгаа хүмүүс дотор улс төрийн хамаарал бүхий магадгүй бас нүүрсний тээвэрт ч гэсэн янз янзаар нэр ус нь холбогдоод яваад байдаг хүмүүстэй холбоотой байж болох хүмүүс ч гэсэн ороод ирчихсэн л байх шиг байна. Тэгэхээр бид нар энэ зүйлүүд дээрээ бас анхааралтай хандахгүй бол шинжээч гэдэг чинь хамаг гол юмнууд хийнэ. Тэгээд бүгдээрээ энэ орж ирж байгаа хүмүүсийнхээ намтар түүх энэ тэрийг нь сайн судлаад сонголтоо хийхдээ нөгөө гар өргөхдөө бас анхааралтай байхыг би бас зөвлөж байна. Тэгээд 12 сарын 4-нд

эхнийг нь хийнэ гэдэг чинь цаг үнэхээр бага болж байна шүү дээ. Төсөв баталсны дараа. Тэгэхээр бид нар гар дээрээ материал энэ тэр хэзээ яаж авч танилцах вэ? Тэрэн дээр бас Түр хорооны дарга гишүүдийг мэдээллээр хангахад бас илүү анхаарч ажиллана уу гэж хэлмээр байна. Баярлалаа.

Б.Энхбаяр: Гишүүд үг хэлж дууслаа. Одоо тогтоолоо энэ юу шүү би өмнө нь ч гэсэн хэлж байсан. Энэ Түр хороон даргаас Түр хорооны гишүүд юм нэхдэгээ болиорой. Энэ чинь хамтдаа Түр хороо байхгүй юу. Тэгээд тийм Түр хорооны даргаас л нэхээд л шаардаад л сүүлдээ одоо тийм утгагүй байдал Хөгжлийн банкн дээр гаргадаг шиг гаргахгүй шүү. Хамтдаа шалгаад хамтын хариуцлага хүлээнэ. Бүгд идэвхтэй оролцох ёстой гэдгийг хэлмээр байна.

Түр хорооны тогтоолын төслийг би түрүүн уншиж сонсгосон.

Тогтоолыг төслийг баталъя гэдгээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Ажлын даалгавар баталж байгаа. Тэгээд л тэр санал болгоод л тавьсан хүн чинь тэр жижиж Тавантолгой компанийн ажнай Бат-Эрдэнэ гишүүний туслахаар нь ажиллаж байсан хүн шинжээчээр ажиллуулчихсан байна лээ шүү дээ. Тэгээд тийм утгагүй юм гэж байж болохгүй шүү дээ. Би өмнөх юун дээр хэлсэн шүү дээ. Энэ чинь ердийн олонхоор билүү юугаар билүү? 83.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

12.53 цагт

Хоёр дахь асуудал. Хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх тухай тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Би тогтоолын төслийг та бүхэнд уншиж сонсоё.

Хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэг болон Төв банкны Монголбанкны тухай хуулийн 25 дугаар зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 18.3 дахь хэсэг 19 дүгээр зүйлийг тус тус үндэслэн төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим компаниудын нүүрс олборлолт, борлуулалт, тээвэрлэлт, экспортын үйл ажиллагаа болон бусад бараа ажил үйлчилгээг худалдан авах үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, нотлох баримтыг шинжлэн судлах зорилгоор Монгол Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос тогтоох нь:

1.Хянан шалгах түр хорооны хянан шалгалтыг эрчимжүүлэх зорилгоор газар дээрх шалгалтын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хянан Шалгагч нэрийг нь унших ёстой юу унших ёсгүй юу энэ чинь бид нар нууцаар баталчихсан шүү дээ хаалттай хурлаар.

Тэгэхээр энд уншихаар чинь ил сонсогдох гээд байна шүү дээ. Тэгэхээр тэрийг гишүүд нөгөө нэрийг нь

тараачихсан учраас та бүхэн харчхаарай.

Хянан шалгагч, шинжээч нэрс нь байна.

2.Ажлын хэсгийн шалгалтын удирдамжийг хавсралтаар баталсугай.

3.Аажлын хэсгийг шалгалтын удирдамжид заасан хүрээнд шуурхай ажиллах боломжоор хангаж зохих журмын дагуу дэмжлэг үзүүлж ажиллахыг холбогдох төрийн байгууллага, хуулийн этгээд, арилжааны банкнуудад үүрэг болгосугай гэсэн тогтоолын төсөл байна.

Тогтоолын төслийг дагалдуулаад шалгалтын ажлын удирдамжийг гаргасан байгаа гэдгийг та бүхэнд хэлье.

Энэ бол ер нь гол нь нөгөө яагаад энийг гаргаж байна вэ гэхээр энэ нөгөө арилжааны банкнуудын мөнгөн гүйлгээг данс хөөх аргаар шалгах гэж байгаа юм. Тэгэнгүүт бас арилжааны банкнуудын зүгээс ингээж үзэх эрхгүй гээд өмнө нь ухуулчихсан. Ухуулахгүй гэдэг асуудал яриад байгаа юм.

Тийм учраас бид нар түр хорооноос тогтоол гаргаад тэгээд яг энэ асуудлуудаар нөгөө мөнгөний араас нь хөөх шаардлага үүсээд байгаа юм.

Тийм учраас ийм тогтоолын төслийг та бүхэнд танилцуулж байгаа. Хугацаа байгаа. 11 дүгээр сарын 7-ноос 11 дүгээр сарын 23 гэсэн хоёр 7 хоногийн хугацаа байгаа. Үгүй энэ хянан шалгагч нар яг данс хөөх гэж байгаа гэсэн үг байхгүй юу.

Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асуух гишүүд байна уу? Алга

байна. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

Тогтоолын төслийг баталъя гэдгээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

100 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

3 дахь асуудалдаа оръё.

3 дахь асуудал хянан шалгах шинжээчдийг томилох тухай асуудал байгаа. энэ асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь хэсгийг тус тус заасныг үндэслэн хаалттай горимоор шилжүүлье гэсэн горимын саналаар санал хураалт явуулъя.

Хянан шалгагч, шинжээчдийг томилохыг.

Санал хураалт 66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг хаалттай горимд шилжүүлье.

12.59 цагт

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА*

